



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 03 дугаар сарын 11
№10 /1208/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠢᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠢᠯ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

207.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	885
208.	Генетик нөөцийн тухай хууль	886
209.	Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай	923
210.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	924
211.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	925
212.	Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	927
213.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	928
214.	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай	931
215.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	932
216.	Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	933
217.	Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	936
218.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай	938

219.	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		939
220.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		940
221.	Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай		941
222.	Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай		943
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
223.	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 104	944
МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
224.	Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл)		946

	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
177	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
77	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
107	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
07	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
17	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
17	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
7	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
7	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
7	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>
7	<p>ТЭГШ</p>	<p>ТЭГШ</p>



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Зөвшөөрч, хүндэтгэн
гэрээлж, баталсан

Мөнхийн
Хүндэтгэн

2022 оны 12 сарын 23 - өдөр

Хүндэтгэн, мөнхийн
Хүндэтгэн

6 сарын 2022 оны 12 сарын 23 өдөр, Улаанбаатар хот, Засгийн газрын өргөн мэдүүлсэнээр соёрхон баталсан “Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан тухай.

Зөвшөөрч, хүндэтгэн

Г.ЗАНДАНШАТАР

Хүндэтгэн, мөнхийн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэх, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх, ашиглах, үр шимийг хүртэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Генетик нөөцийн хууль тогтоомж

2.1.Генетик нөөцийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Байгаль орчныг хамгаалах тухай хууль², Ойн тухай хууль³, Байгалийн ургамлын тухай хууль⁴, Амьтны тухай хууль⁵, Хувиргасан амьд организмын тухай хууль⁶, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль⁷, Иргэний хууль⁸, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь ургамал, амьтан, бичил биетнээс гаралтай генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгт хамааралтай харилцаанд үйлчилнэ.

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

²Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

³Ойн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁴Байгалийн ургамлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁵Амьтны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁶Хувиргасан амьд организмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

⁷Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁸Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

3.2.Энэ хууль нь хүний генетик нөөцтэй холбоотой болон Малын генетик нөөцийн тухай хуулиар⁹ зохицуулсан харилцаанд хамаарахгүй.

3.3.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“амьтан” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасныг;

4.1.2.“биологийн нөөц” гэж генетик нөөц болон бодит, эсхүл боломжит үнэ цэнэ бүхий экосистемийн амьд бүрэлдэхүүн хэсгийг;

4.1.3.“биосоёлын тэмдэглэл” гэж иргэд орон нутгийнхаа генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тодорхойлж, түүнийг бусад этгээдэд ашиглуулах нөхцөлийг хэлэлцэн тохирсон зөвшилцлийг;

4.1.4.“биотехнологи” гэж биологийн систем, амьд биес, тэдгээрээс гаралтай үүсмэлийг ашиглан тодорхой зориулалт бүхий бүтээгдэхүүн, эсхүл арга ажиллагаа бий болгох аливаа технологийг;

4.1.5.“биохайгуул” гэж биологийн олон янз байдлын генетик нөөцийг ашиг олох зорилгоор хайх, судлах үйл явцыг;

4.1.6.“бичил биетэн” гэж энгийн нүдэнд үл үзэгдэх нэг ба олон эст амьд бие, вирусийг;

4.1.7.“генетик материал” гэж ургамал, амьтан, бичил биетний болон бусад эх үүсвэрээс гаралтай удамшлын бүтэц, үйл ажиллагааны нэгж агуулсан аливаа бүрэлдэхүүнийг;

4.1.8.“генетик нөөц” гэж бодит, эсхүл боломжит үнэ цэнэ бүхий генетик материал, үүсмэлийг;

4.1.9.“генетик нөөц ашиглах” гэж генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон ашиг олох

⁹Малын генетик нөөцийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

зорилгоор илрүүлэх, цуглуулах, судлан хөгжүүлэх, бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагааг;

4.1.10.“генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг” гэж аман болон бичмэл, бусад хэлбэрээр өвлөгдөн, уламжлагдаж ирсэн биологийн нөөцийн онцлог шинж чанар, түүнийг ашиглах мэдлэг, арга ухаан, дадлыг;

4.1.11.“генетик нөөцийн материал дамжуулах гэрээ” гэж генетик нөөцийн биет дээж, сорьц, материал, үүсмэлийг ашиглах, эсхүл хадгалах талд тодорхой нөхцөлтэйгөөр дамжуулах хэлцлийг;

4.1.12.“генийн сан” гэж амьд бие, эрхтэн, эд, эс, өсгөвөр, удамшлын материалын биет болон тоон мэдээллийн сан хөмрөгийг;

4.1.13.“олон улсын мэдээлэл солилцооны төв” гэж Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол /цаашид “Нагоягийн протокол” гэх/-ыг соёрхон батлах тухай хуульд¹⁰ заасны дагуу гишүүн орнуудын дунд хэрэгждэг генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын талаарх мэдээлэл солилцох тогтолцоог;

4.1.14.“ургамал” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасныг;

4.1.15.“урьдчилсан зөвшөөрөл” гэж генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгээ ашиглуулж болохыг зөвшөөрсөн эзэмшигчээс өгсөн баталгааг;

4.1.16.“үр шимийн гэрээ” гэж генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, тэдгээрийг ашигласнаас үүдэх үр шимийг хүртэх нөхцөлийг тодорхойлсон генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигч ба ашиглах хүсэлт гаргагчийн хооронд байгуулсан гэрээг;

4.1.17.“үүсмэл” гэж генийн үйл ажиллагаа, бодисын солилцооны дүнд уламжлан үүсэх, байгальд тохиолддог биохимийн нэгдлийг.

¹⁰Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протоколыг соёрхон батлах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

5 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Төрөөс генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглахад дараах зарчим баримтална:

5.1.1. судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлах;

5.1.2. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хамгаалах, зохистой ашиглах;

5.1.3. шийдвэр, үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх;

5.1.4. үр шимийг шударга, эрх тэгш хүртэх.

6 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн өмчлөгч, эзэмшигч

6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаралтай генетик нөөц төрийн өмч байна.

6.2. Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн өвлөн уламжлагч нь тухайн мэдлэгийг энэ хуулийн 10.1-д заасан мэдээллийн санд бүртгүүлж, эзэмшигчээр тогтоолгох хүсэлтээ нотлох баримтын хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/-д хүргүүлнэ.

6.3. Генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн эзэмшигчийг энэ хуулийн 14.5-д заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллага тогтоох бөгөөд тухайн мэдлэг нь түгээмэл ашиглагддаг, эсхүл эзэмшигч нь тогтоогдох боломжгүй тохиолдолд төр эзэмшигч байна.

6.4. Энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, биохайгуул хийх, ашиглах эрхийг хуулийн этгээдэд олгож болно.

6.5. Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг илрүүлэх, биохайгуул хийх, мэдээллийн санд бүртгүүлэхгүй ашиглах, бусдад дамжуулах, худалдах, үр шимийг хүртэхийг хориглоно.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ГЕНЕТИК НӨӨЦ, ГЕНЕТИК НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ
УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ**

**7 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой
уламжлалт мэдлэгийн талаар төрөөс баримтлах
бодлого**

7.1. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэлжүүлэх, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.2. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн инновацын судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжинэ.

7.3. Генетик нөөц, уламжлалт мэдлэг, биотехнологийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэнэ.

7.4. Төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, дэвшилтэт техник, технологи, инновацад суурилсан эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

**8 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой
уламжлалт мэдлэгтэй холбогдох үйл ажиллагааг
хэрэгжүүлэгч байгууллага**

8.1. Төрийн захиргааны төв байгууллага генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2. энэ хуульд заасан урьдчилсан зөвшөөрөл, биосоёлын тэмдэглэл, тусгай зөвшөөрөл, үр шимийн гэрээ, генетик нөөцийн материал дамжуулах гэрээ, газарзүйн гарал үүслийн тодорхойлолтын загварыг батлах;

8.1.3. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, хүчингүй болгох;

8.1.4. устаж үгүй болох эрсдэлд орсон генетик нөөц агуулсан нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамал, амьтны нөөцийн жагсаалтыг баталж, хамгаалах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;



8.1.5.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох;

8.1.6.энэ хуулийн 16.1-д заасан үр шимийн гэрээг мэдээллийн санд бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр шимийн гэрээний нууцлалыг хадгалах;

8.1.7.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж гарган авсан бүтээгдэхүүний үнэ, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлөвийг судлах;

8.1.8.генетик нөөцийн тархац, ангилал зүйн судалгаа, нөөцийн үнэлгээг хийлгэх;

8.1.9.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн судалгаа, тооллого зохион байгуулж, бүртгэх;

8.1.10.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хамгаалах, судлах, ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох этгээдээс мэдээлэл, тайлан гаргуулах;

8.1.11.биологийн судалгааны үр дүн, инновац, ашиг олохын өмнөх болон дараа үеийн холбогдох мэдээллийг тусгай зөвшөөрөл зээмшигчээс гаргуулах;

8.1.12.олон нийтэд генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар мэдлэг олгох ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах;

8.1.13.Нагоягийн протоколын үндэсний зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд олон улсын мэдээлэл солилцооны төвтэй харилцах нэгжтэй байх;

8.1.14.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргах;

8.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

8.2.Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн асуудалд оюуны өмчийн эрх үүссэн эсэхийг хянаж шалгах бөгөөд үүссэн тохиолдолд энэ талаар төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

8.3.Хүнс, хөдөө аж ахуй, анагаах ухаан, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарт хамаарах генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах талаарх ёс зүйн хэм хэмжээг тусгасан ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан энэ хуулийн 9.4.2-т заасны дагуу Мэргэжлийн зөвлөлд хянуулж, батална.

8.4.Төрийн захиргааны төв байгууллага болон энэ хуулийн 8.3-т заасан төрийн захиргааны төв байгууллага Нагоягийн протоколд заасан генетик нөөцийн ашиглалтын хяналтын цэгийн үүргийг гүйцэтгэнэ.

8.5.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.5.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шийдвэрийн биелэлтийг өөрийн нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.5.2.энэ хуулийн 10.3.2-т заасан бүртгэлийг үндэслэн генетик нөөцийн газарзүйн гарал үүслийн тодорхойлолтыг 14 хоногийн дотор олгох;

8.5.3.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигч, ашиглагчийн хооронд байгуулсан үр шимийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

8.5.4.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг болон биосоёлын тэмдэглэлийг бүртгэж, энэ хуулийн 10.3-т заасан мэдээллийн санд ажлын 14 өдрийн дотор байршуулах.

8.6.Гадаад улсаас гаралтай генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу зохих зөвшөөрлийг авсан байна.

8.7.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэх, хадгалах, хамгаалах, ашиглах, судлан хөгжүүлэх санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

8.7.1.улсын болон орон нутгийн төсвөөс;

8.7.2.олон улсын байгууллагын хамтын ажиллагааны оролцооны санхүүжилтээс;

8.7.3.бусад эх үүсвэрээс.

8.8. Улсын төсвөөс дараах зардлыг санхүүжүүлнэ:

8.8.1. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл мэдээллийн сан, генийн сан бүрдүүлж, эрхлэх;

8.8.2. судалгаа, шинжилгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих;

8.8.3. сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

8.8.4. хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

9 дүгээр зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн Мэргэжлийн зөвлөл

9.1. Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий бие даасан, хараат бусаар ажиллах орон тооны бус Мэргэжлийн зөвлөл /цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх/ ажиллана.

9.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн дүрмийг баталж, бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

9.3. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох салбарын эрдэмтэн судлаачид, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

9.4. Мэргэжлийн зөвлөл дараах чиг үүрэгтэй:

9.4.1. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах;

9.4.2. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх биосоёлын тэмдэглэл, энэ хуулийн 8.3-т заасан төрийн захиргааны төв байгууллагаас батлах салбарын ёс зүйн дүрмийн төсөлтэй танилцаж, зөвлөмж гаргах;

9.4.3. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиг олох зорилгоор ашиглах, биохайгуул хийх, судлах хүсэлтийг хянаж дүгнэлт гаргах;

9.4.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн судалгааны ажлын үр дүнтэй танилцаж, дүгнэлт гаргах;



9.4.5.энэ хуулийн 16.1-д заасан үр шимийн гэрээний хэрэгжилтийг хянаж дүгнэлт гаргах;

9.4.6.генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн эзэмшигчийг тогтоох талаар дүгнэлт гаргах.

9.5.Мэргэжлийн зөвлөлийн гишүүд чиг үүргийн хүрээнд олж авсан мэдээллийн нууцыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хуулийн 9.4.3, 9.4.4, 9.4.5, 9.4.6-д заасан судалгааны үр дүн, баримт бичигтэй танилцахын өмнө ашиг сонирхлын мэдүүлгийг бөглөнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЕНЕТИК НӨӨЦ, ГЕНЕТИК НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛЖ ХАМГААЛАХ

10 дугаар зүйл.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан

10.1.Төрийн захиргааны төв байгууллага нь генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-тай байна.

10.2.Мэдээллийн сан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн бүрдэл хэсэг байна.

10.3.Мэдээллийн сан нь дараах дэд сангуудаас бүрдэнэ:

10.3.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн сан;

10.3.2.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын цахим бүртгэл;

10.3.3.генийн сангийн тоон өгөгдлийн сан;

10.3.4.холбогдох бусад мэдээлэл.

10.4.Энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэл нь олон улсын мэдээлэл солилцооны төвтэй холбогдоно.

10.5.Энэ хуулийн 10.1-д заасан мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон мэдээллийн сангийн бүрдэл үзүүлэлтийн жагсаалт, бүртгэлийн маягтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Иргэн, хуулийн этгээд өөрт хадгалагдаж байгаа генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх ном, судар, эрдэм шинжилгээний бүтээл, гар бичмэл, аман мэдээлэл, эдгээртэй адилтгах бусад мэдээллийн цахим хуулбарыг мэдээллийн санд бүртгүүлж, хадгалуулахаар хүргүүлж болно.

10.7.Энэ хуулийн 10.6-д заасан этгээд генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг мэдээллийн санд бүртгүүлж, эзэмшигчээр тогтоогдсон бол үр шим хүртэх эрх үүснэ.

10.8.Энэ хуулийн 10.6-д заасан бүртгэлийг баталгаажуулсан тодорхойлолтыг төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны алба цахим, эсхүл цаасан хэлбэрээр олгоно.

11 дүгээр зүйл.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах

11.1.Генетик нөөц агуулсан ургамал, амьтан, бичил биетнийг уугуул амьдрах орчныг хадгалж тэтгэх, гаршуулж тэжээх, сэлгэх, сэргээн нутагшуулах, тарималжуулах, генийн сан, ургамал, амьтны хүрээлэн байгуулах замаар хамгаална.

11.2.Төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн байгаль орчны албатай хамтран генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн эрэл хайгуул, судалгааг зохион байгуулж мэдээллийн санд бүртгэж хамгаална.

11.3.Нэн ховор, ховор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бол тарималжуулна.

11.4.Төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгт хамаарах энэ хуулийн 10.6-д заасан мэдээллийн нууцлалыг хадгална.

12 дугаар зүйл.Генийн сан

12.1.Генийн санд хамрагдах генетик материалын биет сан хөмрөг, түүний тоон өгөгдлийн санг тухайн чиглэлийн суурь судалгаа хийх үүрэг бүхий байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага төрөлжүүлсэн байдлаар эрхэлж болно.

12.2.Генийн сан эрхлэх байгууллага өөрийн генийн сан дахь генетик материалын мэдээллийг энэ хуулийн 10.3.3-т заасан тоон өгөгдлийн санд хүргүүлнэ.

12.3.Генийн сан байгуулах, сан хөмрөгийг баяжуулж бүртгэх, хадгалж хамгаалах, түгээх, солилцох журам, генийн сангийн дүрмийг байгаль орчны болон боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

12.4.Генийн сангийн хадгалалтын стандартыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЕНЕТИК НӨӨЦ, ГЕНЕТИК НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ АШИГЛАХ

13 дугаар зүйл.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах этгээд

13.1.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тусгай зөвшөөрлийг дараах этгээд /цаашид “хүсэлт гаргагч” гэх/-д олгоно:

13.1.1.Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд;

13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хуулийн этгээд нь гадаадын хөрөнгө оруулалттай бол дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нь 51-ээс доошгүй хувь байх;

13.1.3.дотоодын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээтэй гадаадын хуулийн этгээд.

14 дүгээр зүйл.Урьдчилсан зөвшөөрөл

14.1.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд хүсэлт гаргагч нь тухайн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчээс урьдчилсан зөвшөөрөл авна.

14.2.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг энэ хуулийн 6.3-т зааснаар төр эзэмшиж байгаа бол урьдчилсан зөвшөөрөл авахыг шаардахгүй.

14.3.Энэ хуулийн 14.2-т зааснаар урьдчилсан зөвшөөрөл аваагүй нь энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөхгүй.

14.4.Урьдчилсан зөвшөөрөл авахын өмнө хүсэлт гаргагч нь орон нутгийн иргэдийн биосоёлын тэмдэглэлтэй танилцаж, генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн үнэ цэнэ, үр шимийн талаар эзэмшигчид тайлбарлан таниулна.

14.5.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тогтоох, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журам, биосоёлын тэмдэглэл боловсруулах аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14.6.Хүсэлт гаргагч нь биосоёлын тэмдэглэлтэй танилцан генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчээс урьдчилсан зөвшөөрөл авснаар тухайн эзэмшигчтэй энэ хуулийн 16.1-д заасан үр шимийн гэрээ байгуулах эрх үүснэ.

15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох

15.1.Энэ хуулийн 13.1-д заасан этгээд генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон ашиг олох зорилгоор ашиглах хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

15.1.1.энэ хуулийн 16.1.2-т заасан мэдээлэл болон генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн танилцуулга;

15.1.2.хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

15.1.3.хуулийн этгээдийн танилцуулга;

15.1.4.гадаадын хуулийн этгээд бол дотоодын хуулийн этгээдтэй хийсэн хамтран ажиллах гэрээ;

15.1.5.энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлсэн баримт;

15.1.6.энэ хуулийн 14.1-д заасан урьдчилсан зөвшөөрөл;

15.1.7.энэ хуулийн 8.1.2-т заасан газарзүйн гарал үүслийн тодорхойлолт;

15.1.8.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээний танилцуулга.

15.2.Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн тухай Монгол Улсын олон улсын гэрээнд¹¹ заасан ургамлыг хүнс, тэжээлийн зорилгоор ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.

¹¹Олон Улсын гэрээ соёрхон батлах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

15.3.Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн¹² 3.1.3-т заасан суурь судалгааг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийхэд энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардахгүй.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан судалгааны ажил эхлэхээс өмнө холбогдох мэдээллийг энэ хуулийн 10.3.2-т заасан ашиглалтын цахим бүртгэлд бүртгүүлэх бөгөөд судалгааны ажлын үр дүнг хагас жил тутамд шинэчлэн энэ хуулийн 10.1-д заасан мэдээллийн санд тайлагнах үүрэгтэй.

15.5.Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хүсэлт гаргагчид тусгай зөвшөөрөл олгох эсэхийг Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ажлын 21 өдрийн дотор шийдвэрлэнэ.

15.6.Ургамал, амьтны биологийн нөөц бэлтгэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Амьтны тухай хуулиар тус тус зохицуулна.

15.7.Төрийн захиргааны төв байгууллага дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

15.7.1.Мэргэжлийн зөвлөл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үр шимийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэлт гаргасан;

15.7.2.энэ хуулийн 15.1.4-т заасан хамтран ажиллах гэрээг цуцалсан, эсхүл дуусгавар болгосон;

15.7.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

15.7.4.хуулийн этгээд татан буугдсан;

15.7.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч генетик нөөцийг ашиглахаар заасан хувь, хэмжээг хэтрүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй.

15.8.Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг ашиг олох зорилгоор ашиглах тохиолдолд дахин хүсэлт гаргаж тусгай зөвшөөрөл авна.

15.9.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны болон ашиг олох зорилгоор ашиглаж байгаа хуулийн этгээд энэ хуулийн 13.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ 180 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

¹²Шинжлэх ухаан, технологийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 04 дугаарт нийтлэгдсэн.

15.10.Энэ хуулийн 15.9-д заасан хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүсэлтээ гаргаагүй бол тусгай зөвшөөрөлгүйгээр генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласан гэж үзнэ.

15.11.Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

15.12.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийцлийн гэрчилгээний үндэслэл болох бөгөөд тухайн генетик нөөцийн ашиглалт хуулийн дагуу хэрэгжиж байгааг хянах хэрэгсэл болно.

16 дугаар зүйл. Үр шимийн гэрээ

16.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигчтэй үр шимийн гэрээ байгуулах бөгөөд түүнд дараах нөхцөлийг тусгана:

16.1.1.гэрээний зорилго, хугацаа;

16.1.2.генетик нөөцийг ашиглах зорилго, зориулалт, ургамал, амьтан, бичил биетний шинжлэх ухааны нэр, эсхүл бичил биетний эх үүсвэр, омгийн нэр, өсгөврийн сангийн дугаар, судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн талаарх нөхцөл;

16.1.3.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах зорилго, зориулалт, судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн талаарх нөхцөл;

16.1.4.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах нөхцөл;

16.1.5.генетик нөөцийн материал дамжуулах гэрээ;

16.1.6.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах нөхцөл, төлөвлөгөө;

16.1.7.маргаан шийдвэрлэх зохицуулалт;

16.1.8.ашиглалтаас үүдэх үр шимийг генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчид хүртээх нөхцөл.

16.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үр шимийн гэрээний хуулбар хувийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

17 дугаар зүйл. Генетик нөөцийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл

17.1. Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэ хуулийн 17.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

17.2. Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.3. Бичил биетнийг зөвхөн өсгөвөр хэлбэрээр Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

17.4. Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхдээ генетик нөөцийн биет, эсхүл сорьцын ижил хувийг төрөл, зүйлийн түвшинд тодорхойлуулж, генийн санд хадгалуулсан байна.

18 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим

18.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хуулийн 88.1, 88.2, 88.3-т заасны дагуу генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шимийг эзэмшигчид хүртээнэ.

18.2. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

18.3. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн үр шим нь судалгаа, боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүний борлуулалтын орлого, тусгай зөвшөөрлийн хураамж, оюуны өмчийн эрхийн хамтын эзэмшил болон бусад хэлбэртэй байж болно.

18.4. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн бус үр шим нь дараах дэмжлэг хэлбэртэй байж болно:

- 18.4.1. хамтарсан судалгаа хөгжүүлэлт хийх;
- 18.4.2. чадавч бэхжүүлэх;
- 18.4.3. технологи дамжуулах, багаж тоног төхөөрөмж нийлүүлэх;
- 18.4.4. оюуны өмчийн эрхийн хамтын эзэмшил;
- 18.4.5. холбогдох олон улсын гэрээнд заасан бусад хэлбэр.

18.5.Энэ хуулийн 16.1-д заасан гэрээ байгуулагч талууд хоорондоо харилцан тохиролцож генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шимийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хүртэх тухай асуудлыг гэрээнд тусгана.

19 дүгээр зүйл.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөр

19.1.Амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

19.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийн төлбөр, 17.3-т заасан бичил биетнийг улсын хилээр нэвтрүүлэхэд өсгөврийн тоогоор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд¹³ заасан төлбөр төлнө.

19.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр төлнө.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл.Мэдээ, тайлан гаргах

20.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг доор дурдсан хугацаанд гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

20.1.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа тухай ажлын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор;

20.1.2.мэдээллийн санд орох мэдээллийг тухай бүрд.

21 дүгээр зүйл.Генетик нөөцийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих гаалийн хяналт

21.1.Гаалийн улсын байцаагч генетик нөөцийг улсын хилээр нэвтрүүлэхэд дараах хяналт тавина:

¹³Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

21.1.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх генетик нөөцийг энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн санд бүртгүүлсэн эсэхийг хянаж, тухайн генетик нөөцийн улсын хилээр нэвтэрсэн огноо, холбогдох мэдээллийг мэдээллийн санд оруулах;

21.1.2.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журамд заасан шаардлагыг хангасан эсэх.

22 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

22.1.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹⁴, Зөрчлийн тухай хуульд¹⁵ заасан хариуцлага хүлээлгэнэ.

22.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд¹⁶ заасан хариуцлага хүлээлгэнэ.

23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

23.1.Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

¹⁴Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

Үлэмжлэлийн үүрэг

Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

7. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

8. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

9. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

10. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

11. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

12. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

13. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг

14. Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг, Үлэмжлэлийн үүрэг



- 7 . 10 . 10 . 7 . 11 . 12 . 13 . 14 . 15 . 16 . 17 . 18 . 19 . 20 . 21 . 22 . 23 . 24 . 25 . 26 . 27 . 28 . 29 . 30 . 31 . 32 . 33 . 34 . 35 . 36 . 37 . 38 . 39 . 40 . 41 . 42 . 43 . 44 . 45 . 46 . 47 . 48 . 49 . 50 . 51 . 52 . 53 . 54 . 55 . 56 . 57 . 58 . 59 . 60 . 61 . 62 . 63 . 64 . 65 . 66 . 67 . 68 . 69 . 70 . 71 . 72 . 73 . 74 . 75 . 76 . 77 . 78 . 79 . 80 . 81 . 82 . 83 . 84 . 85 . 86 . 87 . 88 . 89 . 90 . 91 . 92 . 93 . 94 . 95 . 96 . 97 . 98 . 99 . 100 . 101 . 102 . 103 . 104 . 105 . 106 . 107 . 108 . 109 . 110 . 111 . 112 . 113 . 114 . 115 . 116 . 117 . 118 . 119 . 120 . 121 . 122 . 123 . 124 . 125 . 126 . 127 . 128 . 129 . 130 . 131 . 132 . 133 . 134 . 135 . 136 . 137 . 138 . 139 . 140 . 141 . 142 . 143 . 144 . 145 . 146 . 147 . 148 . 149 . 150 . 151 . 152 . 153 . 154 . 155 . 156 . 157 . 158 . 159 . 160 . 161 . 162 . 163 . 164 . 165 . 166 . 167 . 168 . 169 . 170 . 171 . 172 . 173 . 174 . 175 . 176 . 177 . 178 . 179 . 180 . 181 . 182 . 183 . 184 . 185 . 186 . 187 . 188 . 189 . 190 . 191 . 192 . 193 . 194 . 195 . 196 . 197 . 198 . 199 . 200 . 201 . 202 . 203 . 204 . 205 . 206 . 207 . 208 . 209 . 210 . 211 . 212 . 213 . 214 . 215 . 216 . 217 . 218 . 219 . 220 . 221 . 222 . 223 . 224 . 225 . 226 . 227 . 228 . 229 . 230 . 231 . 232 . 233 . 234 . 235 . 236 . 237 . 238 . 239 . 240 . 241 . 242 . 243 . 244 . 245 . 246 . 247 . 248 . 249 . 250 . 251 . 252 . 253 . 254 . 255 . 256 . 257 . 258 . 259 . 260 . 261 . 262 . 263 . 264 . 265 . 266 . 267 . 268 . 269 . 270 . 271 . 272 . 273 . 274 . 275 . 276 . 277 . 278 . 279 . 280 . 281 . 282 . 283 . 284 . 285 . 286 . 287 . 288 . 289 . 290 . 291 . 292 . 293 . 294 . 295 . 296 . 297 . 298 . 299 . 300 . 301 . 302 . 303 . 304 . 305 . 306 . 307 . 308 . 309 . 310 . 311 . 312 . 313 . 314 . 315 . 316 . 317 . 318 . 319 . 320 . 321 . 322 . 323 . 324 . 325 . 326 . 327 . 328 . 329 . 330 . 331 . 332 . 333 . 334 . 335 . 336 . 337 . 338 . 339 . 340 . 341 . 342 . 343 . 344 . 345 . 346 . 347 . 348 . 349 . 350 . 351 . 352 . 353 . 354 . 355 . 356 . 357 . 358 . 359 . 360 . 361 . 362 . 363 . 364 . 365 . 366 . 367 . 368 . 369 . 370 . 371 . 372 . 373 . 374 . 375 . 376 . 377 . 378 . 379 . 380 . 381 . 382 . 383 . 384 . 385 . 386 . 387 . 388 . 389 . 390 . 391 . 392 . 393 . 394 . 395 . 396 . 397 . 398 . 399 . 400 . 401 . 402 . 403 . 404 . 405 . 406 . 407 . 408 . 409 . 410 . 411 . 412 . 413 . 414 . 415 . 416 . 417 . 418 . 419 . 420 . 421 . 422 . 423 . 424 . 425 . 426 . 427 . 428 . 429 . 430 . 431 . 432 . 433 . 434 . 435 . 436 . 437 . 438 . 439 . 440 . 441 . 442 . 443 . 444 . 445 . 446 . 447 . 448 . 449 . 450 . 451 . 452 . 453 . 454 . 455 . 456 . 457 . 458 . 459 . 460 . 461 . 462 . 463 . 464 . 465 . 466 . 467 . 468 . 469 . 470 . 471 . 472 . 473 . 474 . 475 . 476 . 477 . 478 . 479 . 480 . 481 . 482 . 483 . 484 . 485 . 486 . 487 . 488 . 489 . 490 . 491 . 492 . 493 . 494 . 495 . 496 . 497 . 498 . 499 . 500 . 501 . 502 . 503 . 504 . 505 . 506 . 507 . 508 . 509 . 510 . 511 . 512 . 513 . 514 . 515 . 516 . 517 . 518 . 519 . 520 . 521 . 522 . 523 . 524 . 525 . 526 . 527 . 528 . 529 . 530 . 531 . 532 . 533 . 534 . 535 . 536 . 537 . 538 . 539 . 540 . 541 . 542 . 543 . 544 . 545 . 546 . 547 . 548 . 549 . 550 . 551 . 552 . 553 . 554 . 555 . 556 . 557 . 558 . 559 . 560 . 561 . 562 . 563 . 564 . 565 . 566 . 567 . 568 . 569 . 570 . 571 . 572 . 573 . 574 . 575 . 576 . 577 . 578 . 579 . 580 . 581 . 582 . 583 . 584 . 585 . 586 . 587 . 588 . 589 . 590 . 591 . 592 . 593 . 594 . 595 . 596 . 597 . 598 . 599 . 600 . 601 . 602 . 603 . 604 . 605 . 606 . 607 . 608 . 609 . 610 . 611 . 612 . 613 . 614 . 615 . 616 . 617 . 618 . 619 . 620 . 621 . 622 . 623 . 624 . 625 . 626 . 627 . 628 . 629 . 630 . 631 . 632 . 633 . 634 . 635 . 636 . 637 . 638 . 639 . 640 . 641 . 642 . 643 . 644 . 645 . 646 . 647 . 648 . 649 . 650 . 651 . 652 . 653 . 654 . 655 . 656 . 657 . 658 . 659 . 660 . 661 . 662 . 663 . 664 . 665 . 666 . 667 . 668 . 669 . 670 . 671 . 672 . 673 . 674 . 675 . 676 . 677 . 678 . 679 . 680 . 681 . 682 . 683 . 684 . 685 . 686 . 687 . 688 . 689 . 690 . 691 . 692 . 693 . 694 . 695 . 696 . 697 . 698 . 699 . 700 . 701 . 702 . 703 . 704 . 705 . 706 . 707 . 708 . 709 . 710 . 711 . 712 . 713 . 714 . 715 . 716 . 717 . 718 . 719 . 720 . 721 . 722 . 723 . 724 . 725 . 726 . 727 . 728 . 729 . 730 . 731 . 732 . 733 . 734 . 735 . 736 . 737 . 738 . 739 . 740 . 741 . 742 . 743 . 744 . 745 . 746 . 747 . 748 . 749 . 750 . 751 . 752 . 753 . 754 . 755 . 756 . 757 . 758 . 759 . 760 . 761 . 762 . 763 . 764 . 765 . 766 . 767 . 768 . 769 . 770 . 771 . 772 . 773 . 774 . 775 . 776 . 777 . 778 . 779 . 780 . 781 . 782 . 783 . 784 . 785 . 786 . 787 . 788 . 789 . 790 . 791 . 792 . 793 . 794 . 795 . 796 . 797 . 798 . 799 . 800 . 801 . 802 . 803 . 804 . 805 . 806 . 807 . 808 . 809 . 810 . 811 . 812 . 813 . 814 . 815 . 816 . 817 . 818 . 819 . 820 . 821 . 822 . 823 . 824 . 825 . 826 . 827 . 828 . 829 . 830 . 831 . 832 . 833 . 834 . 835 . 836 . 837 . 838 . 839 . 840 . 841 . 842 . 843 . 844 . 845 . 846 . 847 . 848 . 849 . 850 . 851 . 852 . 853 . 854 . 855 . 856 . 857 . 858 . 859 . 860 . 861 . 862 . 863 . 864 . 865 . 866 . 867 . 868 . 869 . 870 . 871 . 872 . 873 . 874 . 875 . 876 . 877 . 878 . 879 . 880 . 881 . 882 . 883 . 884 . 885 . 886 . 887 . 888 . 889 . 890 . 891 . 892 . 893 . 894 . 895 . 896 . 897 . 898 . 899 . 900 . 901 . 902 . 903 . 904 . 905 . 906 . 907 . 908 . 909 . 910 . 911 . 912 . 913 . 914 . 915 . 916 . 917 . 918 . 919 . 920 . 921 . 922 . 923 . 924 . 925 . 926 . 927 . 928 . 929 . 930 . 931 . 932 . 933 . 934 . 935 . 936 . 937 . 938 . 939 . 940 . 941 . 942 . 943 . 944 . 945 . 946 . 947 . 948 . 949 . 950 . 951 . 952 . 953 . 954 . 955 . 956 . 957 . 958 . 959 . 960 . 961 . 962 . 963 . 964 . 965 . 966 . 967 . 968 . 969 . 970 . 971 . 972 . 973 . 974 . 975 . 976 . 977 . 978 . 979 . 980 . 981 . 982 . 983 . 984 . 985 . 986 . 987 . 988 . 989 . 990 . 991 . 992 . 993 . 994 . 995 . 996 . 997 . 998 . 999 . 1000 .

10. 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100. 101. 102. 103. 104. 105. 106. 107. 108. 109. 110. 111. 112. 113. 114. 115. 116. 117. 118. 119. 120. 121. 122. 123. 124. 125. 126. 127. 128. 129. 130. 131. 132. 133. 134. 135. 136. 137. 138. 139. 140. 141. 142. 143. 144. 145. 146. 147. 148. 149. 150. 151. 152. 153. 154. 155. 156. 157. 158. 159. 160. 161. 162. 163. 164. 165. 166. 167. 168. 169. 170. 171. 172. 173. 174. 175. 176. 177. 178. 179. 180. 181. 182. 183. 184. 185. 186. 187. 188. 189. 190. 191. 192. 193. 194. 195. 196. 197. 198. 199. 200. 201. 202. 203. 204. 205. 206. 207. 208. 209. 210. 211. 212. 213. 214. 215. 216. 217. 218. 219. 220. 221. 222. 223. 224. 225. 226. 227. 228. 229. 230. 231. 232. 233. 234. 235. 236. 237. 238. 239. 240. 241. 242. 243. 244. 245. 246. 247. 248. 249. 250. 251. 252. 253. 254. 255. 256. 257. 258. 259. 260. 261. 262. 263. 264. 265. 266. 267. 268. 269. 270. 271. 272. 273. 274. 275. 276. 277. 278. 279. 280. 281. 282. 283. 284. 285. 286. 287. 288. 289. 290. 291. 292. 293. 294. 295. 296. 297. 298. 299. 300. 301. 302. 303. 304. 305. 306. 307. 308. 309. 310. 311. 312. 313. 314. 315. 316. 317. 318. 319. 320. 321. 322. 323. 324. 325. 326. 327. 328. 329. 330. 331. 332. 333. 334. 335. 336. 337. 338. 339. 340. 341. 342. 343. 344. 345. 346. 347. 348. 349. 350. 351. 352. 353. 354. 355. 356. 357. 358. 359. 360. 361. 362. 363. 364. 365. 366. 367. 368. 369. 370. 371. 372. 373. 374. 375. 376. 377. 378. 379. 380. 381. 382. 383. 384. 385. 386. 387. 388. 389. 390. 391. 392. 393. 394. 395. 396. 397. 398. 399. 400. 401. 402. 403. 404. 405. 406. 407. 408. 409. 410. 411. 412. 413. 414. 415. 416. 417. 418. 419. 420. 421. 422. 423. 424. 425. 426. 427. 428. 429. 430. 431. 432. 433. 434. 435. 436. 437. 438. 439. 440. 441. 442. 443. 444. 445. 446. 447. 448. 449. 450. 451. 452. 453. 454. 455. 456. 457. 458. 459. 460. 461. 462. 463. 464. 465. 466. 467. 468. 469. 470. 471. 472. 473. 474. 475. 476. 477. 478. 479. 480. 481. 482. 483. 484. 485. 486. 487. 488. 489. 490. 491. 492. 493. 494. 495. 496. 497. 498. 499. 500. 501. 502. 503. 504. 505. 506. 507. 508. 509. 510. 511. 512. 513. 514. 515. 516. 517. 518. 519. 520. 521. 522. 523. 524. 525. 526. 527. 528. 529. 530. 531. 532. 533. 534. 535. 536. 537. 538. 539. 540. 541. 542. 543. 544. 545. 546. 547. 548. 549. 550. 551. 552. 553. 554. 555. 556. 557. 558. 559. 560. 561. 562. 563. 564. 565. 566. 567. 568. 569. 570. 571. 572. 573. 574. 575. 576. 577. 578. 579. 580. 581. 582. 583. 584. 585. 586. 587. 588. 589. 590. 591. 592. 593. 594. 595. 596. 597. 598. 599. 600. 601. 602. 603. 604. 605. 606. 607. 608. 609. 610. 611. 612. 613. 614. 615. 616. 617. 618. 619. 620. 621. 622. 623. 624. 625. 626. 627. 628. 629. 630. 631. 632. 633. 634. 635. 636. 637. 638. 639. 640. 641. 642. 643. 644. 645. 646. 647. 648. 649. 650. 651. 652. 653. 654. 655. 656. 657. 658. 659. 660. 661. 662. 663. 664. 665. 666. 667. 668. 669. 670. 671. 672. 673. 674. 675. 676. 677. 678. 679. 680. 681. 682. 683. 684. 685. 686. 687. 688. 689. 690. 691. 692. 693. 694. 695. 696. 697. 698. 699. 700. 701. 702. 703. 704. 705. 706. 707. 708. 709. 710. 711. 712. 713. 714. 715. 716. 717. 718. 719. 720. 721. 722. 723. 724. 725. 726. 727. 728. 729. 730. 731. 732. 733. 734. 735. 736. 737. 738. 739. 740. 741. 742. 743. 744. 745. 746. 747. 748. 749. 750. 751. 752. 753. 754. 755. 756. 757. 758. 759. 760. 761. 762. 763. 764. 765. 766. 767. 768. 769. 770. 771. 772. 773. 774. 775. 776. 777. 778. 779. 780. 781. 782. 783. 784. 785. 786. 787. 788. 789. 790. 791. 792. 793. 794. 795. 796. 797. 798. 799. 800. 801. 802. 803. 804. 805. 806. 807. 808. 809. 810. 811. 812. 813. 814. 815. 816. 817. 818. 819. 820. 821. 822. 823. 824. 825. 826. 827. 828. 829. 830. 831. 832. 833. 834. 835. 836. 837. 838. 839. 840. 841. 842. 843. 844. 845. 846. 847. 848. 849. 850. 851. 852. 853. 854. 855. 856. 857. 858. 859. 860. 861. 862. 863. 864. 865. 866. 867. 868. 869. 870. 871. 872. 873. 874. 875. 876. 877. 878. 879. 880. 881. 882. 883. 884. 885. 886. 887. 888. 889. 890. 891. 892. 893. 894. 895. 896. 897. 898. 899. 900. 901. 902. 903. 904. 905. 906. 907. 908. 909. 910. 911. 912. 913. 914. 915. 916. 917. 918. 919. 920. 921. 922. 923. 924. 925. 926. 927. 928. 929. 930. 931. 932. 933. 934. 935. 936. 937. 938. 939. 940. 941. 942. 943. 944. 945. 946. 947. 948. 949. 950. 951. 952. 953. 954. 955. 956. 957. 958. 959. 960. 961. 962. 963. 964. 965. 966. 967. 968. 969. 970. 971. 972. 973. 974. 975. 976. 977. 978. 979. 980. 981. 982. 983. 984. 985. 986. 987. 988. 989. 990. 991. 992. 993. 994. 995. 996. 997. 998. 999. 1000.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 7.2.30 дахь заалт нэмсүгэй:

“7.2.30.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.54 дэх заалт:

“5.1.54. Генетик нөөцийн тухай хуулийн 8.1.3, 8.5.2, 17.3-т заасан тусгай зөвшөөрөл, гарал үүслийн тодорхойлолт, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох.”

2/21 дүгээр зүйлийн 21.1.37 дахь заалт:

“21.1.37. генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгааны зорилгоор ашиглах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 20,000-100,000 төгрөг, ашиг олох зорилгоор ашиглах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 500,000-2,000,000 төгрөг, гарал үүслийн тодорхойлолт олгоход 25,000 төгрөг, бичил биетнийг хилээр нэвтрүүлэх нэг удаагийн зөвшөөрөл олгоход 20,000-500,000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “21.1.30” гэснийг “21.1.37” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 23.4.13 дахь заалт нэмсүгэй:

“23.4.13.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үргэлжлэх хуудал

Хууль тогтоогчийн эрхийн 106-а, 107-а мөр, 108-а мөр

Хууль тогтоогчийн эрхийн 106-а мөр, 107-а мөр

6-р мөр, 107-а мөр, 108-а мөр, 109-а мөр

108-а мөр, 109-а мөр, 110-а мөр, 111-а мөр

112-а мөр, 113-а мөр, 114-а мөр, 115-а мөр

116-а мөр, 117-а мөр, 118-а мөр, 119-а мөр

120-а мөр, 121-а мөр, 122-а мөр, 123-а мөр

124-а мөр, 125-а мөр, 126-а мөр, 127-а мөр

Үргэлжлэх хуудал

Хууль тогтоогчийн эрхийн 106-а мөр, 107-а мөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

“1/7.18 дугаар зүйл.Генетик нөөцийн тухай хууль зөрчих

1.Хуульд заасныг зөрчиж:

1.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тусгай зөвшөөрөлгүйгээр ашигласан;

1.2.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бусдад дамжуулсан, худалдсан бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

2.Хуульд заасан:

2.1.генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ зөвшөөрөл авах;

2.2.генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхдээ генетик нөөцийн биет, эсхүл сорьцын ижил хувийг генийн санд хадгалуулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасан:

3.1.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа тухай ажлын тайлан, мэдээгээ хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

3.2.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үнэ цэнэ, үр шимийн талаар эзэмшигчид тайлбарлан таниулах;

3.3.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тогтоох, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журмыг сахин мөрдөх;



3.4.Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх, мэдээллийн нууцыг хадгалах, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг сахин мөрдөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуульд заасныг зөрчиж:

4.1.генетик нөөц ашигласны төлбөр, мөнгөн болон мөнгөн бус үр шимийг төлөөгүй;

4.2.генетик нөөцийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо мэдүүлээгүй, тоо хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдүүлсэн;

4.3.үр шимийн гэрээнд заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

67010 ТУХАЙ
2022 ОНЫ 10-р сарын 10-ны өдөр
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

6-р бүлэг. Генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн нууцыг хадгалах, генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг сахин мөрдөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Хуульд заасныг зөрчиж:

4.1. генетикийн нөөц ашигласны төлбөр, мөнгөн болон мөнгөн бус үр шимийг төлөөгүй;

4.2. генетикийн нөөцийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо мэдүүлээгүй, тоо хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдүүлсэн;

4.3. үр шимийн гэрээнд заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Генетикийн нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

4.1. генетикийн нөөц ашигласны төлбөр, мөнгөн болон мөнгөн бус үр шимийг төлөөгүй;

4.2. генетикийн нөөцийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо мэдүүлээгүй, тоо хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдүүлсэн;

4.3. үр шимийн гэрээнд заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 23 дахь заалт нэмсүгэй:

“23/.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан.”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “13-18-д” гэснийг “13-18, 23-г” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үндэстний хамтын оюун

Хийгээдэгчдийн оюун

2021 оны 12 сарын 30 өдөр

Урьдчилсан хуралд оролцогчдын оюун
Төрийн захирлын оюун

6 сарын 16-д, Урьдчилсан хуралд оролцогчдын оюун
2021 оны 12 сарын 30 өдөр

Урьдчилсан хуралд оролцогчдын оюун
2021 оны 12 сарын 30 өдөр

7 сарын 16-д, Урьдчилсан хуралд оролцогчдын оюун
2021 оны 12 сарын 30 өдөр

8 сарын 16-д, Урьдчилсан хуралд оролцогчдын оюун
2021 оны 12 сарын 30 өдөр

Үндэстний хамтын оюун
Төрийн захирлын оюун



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3. Ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага судалгаа, шинжилгээний тайлангаа Генетик нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд мэдээлэх үүрэгтэй.”

2/19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7. Генетик нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх.”

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хамгаалах тухай” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай”, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэсний дараа “энэ хуулийн 7^{1.4} дэх хэсэгт нийцүүлэн” гэж, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бэлтгэх” гэсний дараа “, улсын хилээр нэвтрүүлэх” гэж, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “булцуу” гэсний дараа “үндэс болон үрийг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг дотоодын аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар тарималжуулан ашиглаж болно.”

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг:

“25.6.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 25.1, 29.1-д заасан тусгай зөвшөөрөл авахын өмнө Генетик нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.”

2/36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэг:

“36.6.Энэ хуулийн 36.1, 36.2-т заасны дагуу амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, сорьц дээжийг улсын хилээр нэвтрүүлэхдээ Генетик нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.”

2 дугаар зүйл. Амьтны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хамгаалах тухай хууль” гэсний дараа “, Генетик нөөцийн тухай хууль” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Амьтны тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:

“20.3.Иргэн, хуулийн этгээдийн амьтны цуглуулгыг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олгоно.”

2/36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг:

“36.2.Энэ хуулийн 36.1-д заасан амьтнаас бусад амьтныг амьдаар нь, мөн амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шалгалтын тухай хууль,” гэсний дараа “Генетик нөөцийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ / 2021 ОНЫ 12 САРЫН 30-НЫ ӨДӨР /

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ
МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

6 КӨМӨН ХУУЛЬ .. ҮНДЭМ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ / 2021 ОНЫ 12 САРЫН 30-НЫ ӨДӨР /

7 КӨМӨН ХУУЛЬ .. ҮНДЭМ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ / 2021 ОНЫ 12 САРЫН 30-НЫ ӨДӨР /

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ
МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.2.8 дахь заалт:

“7.2.8.генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөрийн орлого.”

2/7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт:

“7.3.12.генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, генийн санг хөгжүүлэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үснэгт, хэсэг, хамрын үснэгт

670010, сар 06, 2021 оны 12 дугаар сарын 30 - өдөр
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Үснэгт, хэсэг, хамрын үснэгт

6. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт

7. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт

8. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт

9. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт

10. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт

11. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт

12. Кэрсэн хэсэг, хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт
Хэсэг, хамрын үснэгт, хамрын үснэгт, хамрын үснэгт

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

“1/24.10 дугаар зүйл. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой мэдлэгийг хууль бусаар ашиглах

1. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол арван таван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг гадаадын иргэн, хуулийн этгээдэд дамжуулан худалдаж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг арван мянган нэгжээс гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Генетик нөөцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Генетик нөөцийн тухай хуульд заасан холбогдох журмыг боловсруулж 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор баталж, мөрдүүлэх;

2/Генетик нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасан генетик нөөц ашигласны үр шимийн төлбөрийг төлөх, төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 03 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үсгэнцэр, бичлэг, гэр, хэргийн үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр 006 - 010 - 016 үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр

Үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээний гэр



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН ДУГААР 9257-MN

МОНГОЛ УЛС
БОЛОН
ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН
ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл)

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хэлэлцээрийг МОНГОЛ УЛС (“Зээлдэгч”) болон ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК (“Банк”)-ны хооронд гарын үсэг зурсан өдөр байгуулав. Зээлдэгч болон Банк нь дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

I ЗҮЙЛ - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөл (энэхүү хэлэлцээрийн хавсралтад тодорхойлсноор) нь энэхүү хэлэлцээрт хамаарах бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөр утгаар заагаагүй тохиолдолд Ерөнхий нөхцөл, эсвэл энэхүү хэлэлцээрийн хавсралтад тодорхойлсон холбогдох нэр томьёонуудын утга нь хэлэлцээрт тодорхойлсон утгатай адил утгатай байна.

II ЗҮЙЛ - ЗЭЭЛ

- 2.01. Банк нь Зээлдэгчид энэхүү хэлэлцээрийн Хуваарь 1-т тодорхойлсон төсөл (“Төсөл”)-ийн санхүүжилтийг дэмжихэд зориулж Мөнгөн Тэмдэгтийг хөрвүүлэх хүснэгтийн (тухай бүр хөрвөх боломжтой) дагуу нэг зуун сая ам.доллар (\$100,000,000)-тай тэнцэх хэмжээний зээл (“Зээл”)-ийг олгохоор тохиров.
- 2.02. Зээлдэгч нь энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2 -ын III хэсэгт заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч зарцуулж болно.



- 2.03. Зээлдэгч нь Зээлийн хэмжээний нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцэх хэмжээний үйлчилгээний шимтгэлийг төлнө.
- 2.04. Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцэх хэмжээгээр төлнө.
- 2.05. Төлөх хүүний хувь хэмжээ нь Лавлах суурь хүү дээр Хувьсах хүүг нэмсэнтэй тэнцүү байх бөгөөд энэ хүү Ерөнхий нөхцөлийн 3.02 (е) хэсэгт заасны дагуу хөрвүүлэлтийн дараа ашиглаж болно.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдөр болон 8 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөх хуваарийн дагуу төлнө.

III ЗҮЙЛ - ТӨСӨЛ

- 3.01. Зээлдэгч нь Төслийн зорилтыг биелүүлэх үүрэг хүлээж байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Энэ хүрээнд Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн V зүйлийн заалтууд болон Төслийн гэрээний заалтын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (“Төсөл хэрэгжүүлэх байгууллага”)–т Төслийг хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог хангах үүрэг хүлээнэ.

IV ЗҮЙЛ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр болох нэмэлт нөхцөлүүд нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (a) Төсөл хэрэгжүүлэх байгууллага нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагыг Банканд нийцсэн хэлбэр, агуулгаар баталсан байна; мөн
 - (b) Төсөл хэрэгжүүлэх байгууллага нь Төслийн удирдлагын албыг Банканд нийцсэн бүрэн эрх, бүрэлдэхүүн, нөөц, ажлын даалгавар/удирдамжтайгаа байгуулсан байна.



- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зуун наяд (180) дахь өдөр байна.

V ЗҮЙЛ - ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ

- 5.01. Зээлдэгчийн Төлөөлөгч нь түүний санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

- 5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01-д заасан зорилгоор:

- (a) Зээлдэгчийн хаяг нь:

Сангийн Яам
Засгийн газрын II байр
С. Данзангийн гудамж, 5/1 Д
Улаанбаатар-15160
Монгол Улс; мөн

- (б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс:
976-11-320247

- 5.03. Ерөнхий нөхцөлийн 10.01-д заасан зорилгоор:

- (a) Банкны хаяг нь:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
1818 Н Гудамж, N.W.
Вашингтон D.C. 20433
Америкийн Нэгдсэн Улс; болон

- (б) Банкны цахим хаяг нь:

Телекс: 248423(MCI) эсвэл 64145(MCI)
Факс: 1-202-477-6391

энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөр ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____



ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч
Нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн тодорхойлолт

Төслийн зорилго нь Улаанбаатар хотод тогтвортой авто зам, тээврээр хангах цогц тогтолцоог боловсруулах, сонгосон авто зам, тээврийн коридорт замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, авто замын аюулгүй байдлыг сайжруулах, цаг агаарын гаралтай асуудлуудыг шийдвэрлэхэд тус тус оршино.

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1 дэх хэсэг. Цогц коридорууд

- 1.1. Коридорт зориулсан дэд бүтцийн хөрөнгө оруулалт. Дараах зүйлд зориулсан барилгын ажил хийж гүйцэтгэх: (а) коридорын сэргээн засварлалт ба өөрчлөн зохион байгуулалт, үүний дотор авто замын зурвас болон явган хүний замыг сэргээн засварлах, сонгосон гудамжны замын хөндлөн огтлолын орон зайг өөрчлөн зохион байгуулах, замын уулзварыг сувагжуулах, замын хөдөлгөөний инженерчлэлийн нэмэлт байгууламжуудыг суурилуулах; мөн (б) Авто замын коридорын шинэ бүтээн байгуулалт ба шинэчлэлээр гудамж замыг өргөтгөх.
- 1.2. Тээврийн ухаалаг системүүд. Бусад зүйлсийн зэрэгцээ замын гэрлэн дохионы удирдлага, ашиглалтын систем ба түүний тоног төхөөрөмжийг багтаасан замын хөдөлгөөний удирдлагын төвлөрсөн системийг шинэчлэх; мөн бусад зүйлсийн зэрэгцээ замын гэрлэн дохио, замын хөдөлгөөний дүрмийн даган мөрдүүлэлт, хяналтын камер зэргийг багтаасан гудамж дахь тээврийн ухаалаг системүүдийг шинэчлэх.

- 1.3. Авто зогсоолын удирдлагын ухаалаг систем. (а) Тоног төхөөрөмж суурилуулах, системд зориулсан программ хангамж боловсруулах, (б) ялгавартай үнэ бүхий бүсчилсэн зогсоолын системийг нэвтрүүлэх замаар авто зогсоолын удирдлагын ухаалаг системийг боловсруулж, ажиллуулах.

2 дахь хэсэг. Тогтвортой нийтийн тээврийн систем

- 2.1. Коридорт зориулсан хөрөнгө оруулалтууд. Автобус зорчих эгнээнүүдийг байгуулах, Төслийн 1.1 хэсгийн хүрээнд сонгосон коридоруудын дагуу автобусны зогсоолуудыг сайжруулах ; мөн
- 2.2. Хотын хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалтууд. Нийтийн тээврийн удирдлагын системийг шинэчлэх, эрэлтэд суурилсан тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх.

3 дахь хэсэг. Зам, тээврийн төлөвлөлт болон удирдлагын үр өгөөжтэй институт

- 3.1. Стратегийн судалгаанууд. Хотын авто зам, тээврийн стратеги болон Улаанбаатар хотын авто зогсоолын удирдлагын төлөвлөгөө; зам, замын байгууламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, удирдлага, авто замын аюулгүй байдал болон нийтийн тээвэр чиглэлээр стратегийн судалгаа хийх.
- 3.2 Чадавхыг бэхжүүлэх, хэрэгжилтийг дэмжих. Дараах зүйлд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх. Үүнд: (а) төслийн удирдлага, зохицуулалт, үүний дотор санхүүгийн удирдлага, хөрөнгийн зарцуулалт, худалдан авалт, байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн удирдлага, гомдлыг хянан шийдвэрлэх механизмууд, мониторинг, тайлан болон үнэлгээ; (б) төслийн үйл ажиллагааны техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслүүдийг боловсруулах; мөн (в) чадавхыг бэхжүүлэлт ба зам, замын байгууламжийн төлөвлөлт, удирдлагатай холбоотой сонгосон сэдвүүдийн чиглэлээр сургалт.

4 дэх хэсэг. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

Шаардлагатай тохиолдолд хүлээн зөвшөөрөгдсөн хямрал, онцгой байдлын нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

ХУВААРЬ 2

Төслийн хэрэгжүүлэлт

I хэсэг. Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт

A. Дамжуулан зээлдүүлэх гэрээ.

1. Төсөл гүйцэтгэх ажлыг хөнгөвчлөхийн тулд Банкнаас баталсан нөхцөл, болзлын дагуу Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэх байгууллага хоёрын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Зээлийн хөрөнгийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад олгоно.
2. Зээлдэгч тус Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгогдсон эрхээ Зээлдэгч болон Банкны эрх ашгийг хамгаалж, мөн тус зээлийн зорилтыг хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлнэ. Банктай өөрөөр тохиролцоогүй бол Зээлдэгч тус дамжуулан зээлдүүлэх гэрээ, түүний аливаа зүйл заалтыг бусдад шилжүүлж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүчингүй болгох, эсвэл түдгэлзүүлэхийг хориглоно.

B. Байгаль орчны болон нийгмийн стандартууд.

1. Зээлдэгч нь Төслийн гэрээний Хуваарийн хэсэг I.Г дэх заалтуудыг мөрдөхөд бүх шаардлагатай арга хэмжээг авах, мөн Төсөл хэрэгжүүлэх байгууллагыг зохих нөхцөлөөр хангасан байна.

B. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ.

1. Төслийн 4 дүгээр хэсэг (“Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэг”)-ийн хүрээнд болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний зохих хэрэгжилтийг хангах зорилгоор Зээлдэгч нь дараах зүйлийг хангасан байна. Үүнд:

- (a) Гарын авлага (“Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага”)-ыг Банкнаас хүлээн зөвшөөрөх хэлбэр, агуулгатайгаар боловсруулж



хэрэгжүүлэх бөгөөд түүнд (i) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт зориулан зохицуулах, хэрэгжүүлэх аливаа бүтэц, эсвэл байгууллагын зохицуулалт; (ii) онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт тусгаж болох тодорхой үйл ажиллагаа, түүнд шаардагдах зөвшөөрөгдсөн зардлууд (“онцгой байдлын үеийн зардлууд”) болон ийнхүү тусгах аливаа журам; (iii) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт зориулсан санхүүгийн удирдлагын зохицуулалт; (iv) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт зориулсан худалдан авалтын аргууд болон журам; (v) онцгой байдлын үеийн зардлыг санхүүжүүлэх хэмжээний хөрөнгийг зарцуулахад шаардагдах баримт бичиг; (vi) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт зориулсан байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, удирдлагын зохицуулалтын тодорхойлолт; мөн (vii) онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний загвар зэргийг багтаан болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт зориулан хэрэгжүүлэх дэлгэрэнгүй зохицуулалтыг тусгасан байна;

- (б) Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг Банкнаас хүлээн зөвшөөрөх хэлбэр, агуулгатайгаар боловсруулж хэрэгжүүлнэ;
- (в) Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийг Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага болон Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ, ингэхдээ Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага, эсвэл Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний заалтууд энэхүү Хэлэлцээрийн заалтуудтай зөрчилдөх тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг баримтална; мөн
- (г) Банкнаас урьдчилж бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага, эсвэл Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний аль алинд нэмэлт, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлахыг хориглоно.



2. Зээлдэгч нь Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлагад тусгасан бүтэц болон байгууллагын зохицуулалтыг Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд Банкны шаардлагад нийцэх хангалттай тооны ажилтан, эх үүсвэртэй байлгах явдлыг хангасан байна.
3. Зээлдэгч нь дараах зүйлийг хангасан байна. Үүнд:
 - (а) Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт шаардлагатай байгаль орчны болон нийгмийн хэрэгслүүдийг Банкнаас хүлээн зөвшөөрөх хэлбэр, агуулгатайгаар Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага болон Байгаль орчны болон нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний дагуу боловсруулж, олон нийтэд мэдээлж хэрэгжүүлнэ; мөн
 - (б) Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийг Банкнаас хүлээн зөвшөөрөх байдлаар байгаль орчны болон нийгмийн хэрэгслүүдийн дагуу хэрэгжүүлнэ.
4. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хүрээн дэх үйл ажиллагааг зөвхөн Хүлээн зөвшөөрөгдсөн хямрал, эсвэл онцгой байдлын нөхцөл бий болсон үед л хэрэгжүүлнэ.

II хэсэг. Төслийн хяналт, тайлагнал ба үнэлгээ

Зээлдэгч нь хуанлийн хагас жилийг хамруулсан Төслийн тайлан тус бүрийг хуанлийн хагас жилээс хойш нэг сарын дотор Төсөл хэрэгжүүлэх байгууллагыг Банканд хүргүүлэх нөхцөлөөр хангана.

III хэсэг. Зээлийн хөрөнгийн зарцуулалт

A. Ерөнхий заалт.

Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II зүйлийн заалтуудаар үл хязгаарлагдан, мөн Зарцуулалтын болон санхүүгийн мэдээллийн захидлын дагуу Зээлийн хөрөнгийг дараах зүйлд хуваарилсан дүнгээр Зөвшөөрөгдсөн зардал болон дараах хүснэгтэд ангилал тус бүрд заасан дүнгээр санхүүжилт хийхээр татан авалт хийж болно:



| Ангилал | Хуваарилсан зээлийн хэмжээ (Ам.доллараар илэрхийлсэн) | Зардлыг санхүүжүүлэх хувь хэмжээ (Татварыг орсон) |
|--|---|---|
| (1) Төсөлд зориулсан бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, сургалт | 100,000,000 | 100% |
| (2) Онцгой байдлын үеийн зардал | 0 | 100% |
| НИЙТ ДҮН | 100,000,000. | |

Б. Хөрөнгө гаргах нөхцөлүүд, хугацаа

1. Дээрх А хэсгийн заалтуудаас үл хамааран дараах зүйлд зарлага гаргахыг хориглоно. Үүнд:

- (a) гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийгдсэн төлбөр; гэвч ангилал 1 дэх Хүлээн зөвшөөрөх зарлагад зориулан 6 дугаар сарын 1-ний өдөр болон энэ өдрөөс хойш хийсэн төлбөрт зориулан нийт хорин сая ам.доллар (20,000,000) хүртэлх төлбөрийг хийж болно; эсхүл
- (б) Дараах бүх нөхцөлийг хангасан тохиолдолд (2) Ангиллын хүрээнд багтах Онцгой байдлын үеийн зарлагууд:
 - (i) (А) Зээлдэгч нь Хүлээн зөвшөөрөгдсөн хямрал, онцгой байдлын нөхцөл бий болсон гэж тодорхойлсон, мөн (2) Ангиллын хүрээнд Зээлийн хөрөнгийг гарах хүсэлтийг Банканд хүргүүлсэн; мөн (Б) Банк нь ийм тодорхойлолтыг зөвшөөрч дээр дурдсан хүсэлтийг хүлээн авсан, энэ тухай Зээлдэгчид мэдэгдсэн; мөн
 - (ii) Зээлдэгч нь Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага болон Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг Банкнаас хүлээн зөвшөөрөх хэлбэр, агуулгатайгаар боловсруулан мөрдөж байгаа.

2. Төслийн дуусгавар болох хугацаа нь 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.

ХУВААРЬ 3

Зээлийн амлалтад уялдсан эргэн төлөлтийн хуваарь

Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн төлбөр хийгдэх өдрүүд болон тухайн төлбөр хийх өдөр тус бүр зээлийн хөрөнгөөс эргэн төлөгдөх хувь хэмжээг тогтоосон (“Төлбөрийн хувь хэмжээ”).

Зээлийн амлалттай уялдсан эргэн төлөлт

| Үндсэн төлбөр хийгдэх огноо | Төлбөрийн хувь хэмжээ |
|---|-----------------------|
| Жил бүрийн 2 дугаар сарын 15-ны болон 8 дугаар сарын 15-ны өдрүүдэд
2026 оны 2 дугаар сарын 15-наас эхлэн
2051 оны 8 дугаар сарын 15-н хүртэл | 2 % |

ХАВСРАЛТ

Тодорхойлолт

1. “Ажлын жилийн төлөвлөгөө, төсөв”, товчилсноор “АЖТТ” гэж тус бүрдээ Төслийн гэрээний Хуваарийн I.Б дэх хэсэгт тусгасан төлөвлөгөө, төсвийг хэлнэ; өмнө дурдсаны дагуу Банкнаас урьдчилж бичгээр үйлдсэн зөвшөөрөлтэйгөөр түүнийг үе үе өөрчилж болно.
2. “Авлигын эсрэг зааварчилгаа” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 6 дугаар догол мөрийн зорилгоор 2011 оны 10 дугаар сарын 15-ны өдөр болон 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн төслүүдэд залилан болон авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зааварчилгааг хэлнэ.
3. “Ангилал” гэж энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-ын III.A хэсэгт тусгасан хүснэгтэд заасан ангиллыг хэлнэ.
4. “Болзошгүй онцгой байдлын үед авах арга хэмжээний хэсэг” гэж Хүлээн зөвшөөрөгдсөн хямрал, эсвэл онцгой байдлын үед Төслийн 4 дүгээр хэсгийн хүрээнд авах хариу арга хэмжээний хүрээний аливаа үйл ажиллагааг хэлнэ.

5. “Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага” гэж энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.Б хэсэгт тусгасан гарын авлагыг хэлнэ, ийм гарын авлага нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагын салшгүй хэсэг бөгөөд түүнийг Банкны зөвшөөрлийн дагуу үе үе баяжуулан өөрчилж болно.
6. “Хүлээн зөвшөөрөгдсөн хямрал, эсвэл онцгой байдал” гэж байгалийн, эсвэл хүний үйлдлээс үүссэн хямрал, эсвэл гамшигтай холбоотойгоор Зээлдэгчид эдийн засгийн болон/эсвэл нийгмийн томоохон сөрөг үр дагавар учруулсан, эсвэл зайлшгүй учруулах магадлалтай үйл явдлыг хэлнэ.
7. “Онцгой байдлын үеийн зардлууд” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.Б хэсгийн заалтуудын дагуу Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлагад тусгасан, Болзошгүй онцгой байдлын үед авах арга хэмжээний хэсэгт шаардагдах зөвшөөрөгдсөн аливаа зардлыг хэлнэ.
8. “Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”, гэж зөвшөөрөгдсөн хямрал, эсвэл онцгой байдлын үед хариу арга хэмжээний үйл ажиллагаа, төсөв, хэрэгжүүлэх төлөвлөгөө, мониторинг болон үнэлгээний зохицуулалтыг дэлгэрэнгүйгээр тодорхойлсон, I.Б дэх хэсэгт тусгасан төлөвлөгөөг хэлнэ.
9. “Байгаль орчны болон нийгмийн хариуцлагын төлөвлөгөө”, эсвэл товчилсноор “БОНХТ” гэж энэхүү Хэлэлцээрт заасны дагуу үе үе өөрчлөгдөж болох 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Төслийн байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг хэлнэ. Энэ нь Төслөөс байгаль орчин болон нийгэмд үзүүлж болзошгүй эрсдэл болон нөлөөллийг арилгахын тулд арга хэмжээ авах, үйл ажиллагаа явуулах хугацаа, байгууллагын зохицуулалт, боловсон хүчин, сургалт, мониторинг болон тайлагнах зохицуулалт, түүнд бэлтгэх байгаль орчны болон нийгмийн бусад хэрэгслүүдийг багтаасан, Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэх байгууллагаас хэрэгжүүлэх, эсвэл хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах материаллаг арга хэмжээ болон үйл ажиллагааг тодорхойлсон төлөвлөгөө юм.
10. “Байгаль орчны болон нийгмийн стандартууд”, эсвэл товчилсноор “БОНС”-ууд гэж 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж Банкаас хэвлэн гаргасан, хамтдаа: (i) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага”; (ii) “Байгаль орчны болон

нийгмийн стандарт 2: Ажиллах хүч ба хөдөлмөрийн нөхцөл”; (iii) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 3: Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх ба удирдлага”; (iv) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 4: Нутгийн иргэд, бүлгийн эрүүл мэнд ба аюулгүй байдал”; (v) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 5: Газар чөлөөлөлт, газрын ашиглалтын хязгаарлалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт”; (vi) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага”; (vii) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 7: Уугуул иргэд/ Өмнөд Африкын Сахарын үе дамжин орхигдсон нутгийн иргэд, иргэдийн бүлгүүд”; (viii) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлагч”; (x) “Байгаль орчны болон нийгмийн стандарт 10: Талуудын оролцоог хангах ба мэдээллийн ил тод байдал” стандартуудыг хэлнэ.

11. “Ерөнхий нөхцөл” гэж, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтийн, мөн Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтэд зориулсан, 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн (2020 оны 8 дугаар сарын 1-ний өдөр, 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр болон 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр шинэчлэн найруулсан) Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны Ерөнхий нөхцөлийг хэлнэ.
12. “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж Зээлдэгчийн ижил нэр бүхий хотын захиргаа, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
13. “Үйл ажиллагааны зардал” гэж Зээлдэгчийн төрийн албаны ажилтнуудын цалин, урамшуулал, хураамж, мөнгөн төлбөр болон тэдгээртэй адилтгах төлбөрөөс бусад тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламж, албан байрны лизингийн болон /эсвэл урсгал засвар болон засвар үйлчилгээ, шатахуун, албан хэрэгцээний зүйлс, нийтийн аж ахуйн зардал, хэрэглээний материал, харилцаа холбооны зардал (үүнд: шуудан, утас болон интернэтийн зардал), унаа, орчуулга, хэвлэх, хувилах зардал, банкны шимтгэл, хураамж, хэвлэлийн болон сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой уулзалтын зардал, Төсөлтэй холбоотой аялал, томиллолт, байрны зардал, Төсөлтэй шууд холбоотой гэрээт туслах ажилтнууд болон захиргааны бусад зардал зэрэг Төслийн үйл ажиллагааны өдөр тутмын зохицуулалт,

- зохион байгуулалт болон хяналт хийхэд шаардагдах бараа болон зөвлөхийн бус үйлчилгээний үндэслэлтэй зардлыг хэлнэ.
14. “Худалдан авах ажиллагааны дүрэм” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 87 дахь догол мөрний зорилгоор 2020 оны 11 дүгээр сард гаргасан “Хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийн Зээлдэгч нарт зориулсан Дэлхийн Банкны Худалдан авах ажиллагааны дүрэм”-ийг хэлнэ.
 15. “Төсөл хэрэгжүүлэх байгууллага” гэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг хэлнэ.
 16. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэж Төсөл хэрэгжүүлэх байгууллага боловсруулан батлах, Төслийг хэрэгжүүлэх явцад баяжуулан шинэчлэх гарын авлагыг хэлнэ. Түүнд (А) дараах зохицуулалт, журмыг дэлгэрэнгүй тусгасан байна: (а) байгууллагуудын зохицуулалт, Төслийн өдөр тутмын гүйцэтгэл; (б) хөрөнгийн зарцуулалт болон санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлагын арга хэмжээ; (д) мониторинг, үнэлгээ, тайлан болон харилцаа холбоо; (е) бүрэн бүтэн байдлын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө; (ё) олон улсын сайн туршлага, Төслийг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг роль болон хариуцлагын дагуу хувийн мэдээлэл цуглуулж боловсруулах; (ж) Төсөлд шаардагдах захиргааны, санхүү, техникийн болон зохион байгуулалтын бусад зохицуулалт болон журам; мөн (Б) Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлага: тус гарын авлагыг Банкнаас урьдчилж бичгээр үйлдсэн зөвшөөрөл авсны дараа үе үе өөрчилж болох бөгөөд ийм нэр томьёо нь ийм гарын авлагын аливаа хуваарийг багтаасан болно.
 17. “Төслийн удирдлагын алба” гэж Төслийн гэрээний Хуваарийн I.A.2. (б) дэх хэсэгт тусгасны дагуу Төсөл хэрэгжүүлэх байгууллагын байгуулсан, цаашид ажиллуулах алба, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
 18. “Төслийн удирдах хороо” гэж Төслийн гэрээний Хуваарийн I.A.2. (а) дахь хэсгийн дагуу Төсөл хэрэгжүүлэх байгууллагын байгуулсан, цаашид ажиллуулах хороо, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
 19. “Нийтийн тээврийн үйлчилгээний газар” гэж Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийтийн тээврийн үйлчилгээний газар, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.

20. “Гарын үсэг зурсан өдөр” гэж Зээлдэгч болон Банк энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр өдрийн сүүлчийн өдөр бөгөөд ийм тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлд тусгасан «Зээлийн хэлэлцээрийн огноо» гэсэн бүх эшлэлд хамаарна.
21. “Нийслэлийн автозамын хөгжлийн газар” гэж Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Автозамын хөгжлийн газар, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
22. “Замын хөдөлгөөний удирлагын төв” гэж Нийслэлийн Засаг даргын харьяа Замын хөдөлгөөний хяналтын төв, эсвэл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
23. “Сургалт” гэж Зээлдэгчийн төрийн албаны ажилтнуудын зөвлөх үйлчилгээний төлбөр, цалин, урамшуулал, хураамж, мөнгөн төлбөр болон тэдгээртэй адилтгах төлбөрөөс бусад Банкнаас баталсан сургалтын төлөвлөгөө, үүний дотор сургалт, семинар, танилцах аялалд оролцогчдын аялал, томилолтын зардал, сургагч багшийн үйлчилгээг баталгаажуулах, сургалт, семинар хийх байр түрээслэх, сургалт, семинарын материалыг бэлтгэх, хуулбарлахтай холбоотой зардал болон бусад зардалд үндэслэн Төслийн хүрээнд зохион байгуулах сургалтын үйл ажиллагаа, семинар болон танилцах аливаа аялалд ажилтнууд оролцоход шаардагдах бараа, үйлчилгээний үндэслэлтэй өртөг зардлыг хэлнэ.
24. “Улаанбаатар” гэж Зээлдэгчийн ижил нэр бүхий нийслэл хотыг хэлнэ.



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5

Индекс: 200003